

Бүгд Найрамдах Чех улсын Элчин сайдын яамны Нэгдүгээр нарийн бичгийн дарга Ноён Олдржих Заяычекийн 2015 оны 8 дугаар сарын 11-ний өдөр зохиогдсон “Монгол орны ойн болон орон нутгийн ой модны генийн сангийн хөгжил” төслийн нээлтийн арга хэмжээнд хэлсэн үг

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Хүндэт ноён Ц. Цэнгэл,

Гадаад хамтын ажиллагааны газрын Дарга Хүндэт ноён Б. Ерөөлт,

Ойн бодлого зохицуулалтын газрын Дарга Хүндэт ноён Ц. Банзрагч,

Ойн судалгаа, хөгжлийн төв УТУГ-ын Дарга Хүндэт ноён С. Гантулга,

БНЧУ-ын Брэндис над Лабэм дах Ойн аж ахуйн хүрээлэнгийн Төслийн удирдагч Хүндэт ноён Слаби,

Чехийн хөгжлийн агентлагийн Мэргэжилтэн хатагтай Худа болон

энд хүрэлцэн ирсэн хүндэт зочид, ноёд, хатагтай **нараа**

Манай 2 орны хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойг тэмдэглэж буй энэ жил бид БНЧУ болон Монгол улсын хоорондох нөхөрлөл, хамтын ажиллагаагаа улам бүр гүнзгийрүүлж байгаа нь билэгшээлээс ч илүү үйл явдал болж байна.

Сүүлийн жилүүдэд манай 2 орны төрийн өндөрлөгүүд хоорондын холбоо харилцаагаа идэвхжүүлж байна. Тухайлбал, Монгол улсын ерөнхийлөгч Хүндэт ноён Ц. Элбэгдорж, бүрэлдэхүүний хамтаар 2015 оны 1 дүгээр сард БНЧУ-д айлчилсан бол БНЧУ-ын Парламентын Дарга Хүндэт ноён Я. Хамаачек Анхны чөлөөт ардчилсан сонгуулийн 25-н жилийн ойг тохиолдуулан Монголын ард түмэнд баяр хүргэхийн ялдамд бидний 2 талт хамтын ажиллагааг бэхжүүлэх үүднээс дөнгөж саяхан Монгол улсад айлчилсан юм.

Манай 2 орны өнөөгийн харилцаа нь харилцан анхаарал хандуулдаг олон салбарыг хамардаг. Өнгөрсөн он жилүүдэд Чехүүд Монголын ард түмэнд туслахаар энд байсан бөгөөд одоо ч гэсэн бүхий л салбарт тусалж хамтран ажиллахаар Монголд байсан хэвээр байна. Байгаль орчныг хамгаалах нь бидний хамтын ажиллагааны маш чухал талбаруудын нэг юм.

Монголд ирээд богинохон хугацааны дараа би энд зогсоод Чехийн Хөгжлийн Агентлагтай хамтран хэрэгжүүлэх өөр нэгэн чухал төсөл албан ёсоор эхлэж байгааг хэлэхдээ таатай байна.

БНЧУ-аас нийтдээ 1 сая гаруй долларын санхүүжилт олгож буй “Монгол орны ойн болон орон нутгийн ой модны генийн сангийн хөгжил” төслийг голлон Дархан аймгийн Хонгор ба Шарын гол сумын нутаг дэвсгэрт Монголын яамд, Дархан дах ХААИС-ийн харьяа Ургамал, Газар Тариалангийн Хүрээлэнгийн Агроэкологи Бизнесийн сургууль, Сэлэнгэ аймгийн МСҮТ болон Чехийн талаас БНЧУ-ын Брэндис над Лабэм дах Ойн аж ахуйн хүрээлэн хамтран хэрэгжүүлэх юм.

Би Дарханы Их сургууль болон Трутновын Ойн Академи нь он удаан жилийн хамтын ажиллагааны түүхтэй болохыг олж мэдсэн бөгөөд уг сургуулийн төгсөгчдийн нэг болох Ноён Слаби Чехийн талаас Төслийн удирдагч болсныг дуулгахдаа таатай байна.

Өнгөрсөн хугацаанд БНЧУ-д суралцан төгссөн олон Монгол иргэд бидний найрамдал, хамтын ажиллагааг **эрчимжүүлж** байдагт би маш баяртай байдаг бөгөөд манай улсуудын хоорондох амжилттай солилцоо цаашид ч үргэлжилнэ гэж итгэж байна.

Монголын талд бидний санал болгож буй **зүйл** нь Орон нутгийн ойн модны төрлүүдийн генийн санг хөгжүүлж хадгалж авч үлдэх замаар “Ойн бүсчилсэн хөгжил”-ийн урт хугацааны нарийн төлөвлөгөөг ашиглан ойг хэрхэн арчлах гүн гүнзгий мэдлэг, ноу хау бүхий туршлагатай экспертүүдийн баг юм. Ялангуяа уур, амьсгалын өөрчлөлт болон Монголын газар нутагт цөлжилт нэмэгдэж буйг харгалзан үзэж өнөөдөр бид ойг хэрхэн хадгалж, хөгжүүлэх бүхий л боломжит арга хэрэгслээ ашиглах ёстой болоод байгаа юм. Чехийн экспертүүд нь төсөл хэрэгжих 2015-2017 оны хооронд мод үржүүлгийн төвүүдийг байгуулан ажиллуулах явцад нарийн мэргэшлийн туслалцаа үзүүлнэ. Мөн Чехийн экспертүүд ойн тогтвортой менежментийн үзэл баримтлалд тулгуурлан Монгол талын түншүүд, мод үржүүлгийн төвийн ажилчид, орон нутгийн удирдлагууд, мөн сургагч багш нартай нягт хамтран ажиллах юм. Мөн сургагч багш нар нь бусад төсөлд оролцох боломжоор хангагдах бөгөөд төслийн үйл ажиллагааг харгалзах хүмүүс ба олон нийтэд байнга толилуулж байх юм.

Уг төслийг эхлүүлж байгаа нь энэ салбар дах бидний хамтын ажиллагааны зөвхөн эхлэл бөгөөд төслийн үр дүн нь Чех болон Монгол экспертүүдийн сонгосон арга зам нь зөв гэдгийг бидэнд батлан харуулна гэж найдаж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Илүү сайхан амьдралын төлөө ойг хөгжүүлцгээе.